



НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/495 дугаар захирамж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 10/13 тоот тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:


1. "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.1 дүгээр заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн "Улаанбаатар инноваци хөгжлийн төв"-ийг байгуулахад тавилгыг худалдан авах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах "Үнэлгээний хороо"-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга	Ж.Билэгсайхан	Газрын орлогч дарга
Гишүүд:	Д.Анхбат	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Д.Батболд	Иргэний төлөөлөл /зөвшилцсөнөөр/
	Ж.Тамжид	Захиргааны хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	О.Ойгонбаяр	Инновацийн хэлтсийн мэргэжилтэн

2. Батлагдсан төсөв, арга хэмжээний хүрээнд худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэл үр дүнг хариуцан ажиллахыг Үнэлгээний хороо /Ж.Билэгсайхан/-д даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /О.Ойгонбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ

D:My doc/tushaal/2018

115050000014